



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/495

Хэрлэн сум

Усан халаалтын зуух худалдаж  
авахад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2022 оны 9 дүгээр сарын 15-ны 81/06/02 дугаар дүгнэлт, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2022 оны 9 дүгээр сарын 14-ний 22-07-028/110 дугаар дүгнэлтээр 10 орон сууц, 9 аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангах боломжгүй гамшгийн онцгой нөхцөл байдал үүсэх эрсдэл гарсан тул "Хэнтий-Ус" ХХК-ийн 7 дугаар халаалтын зууханд шаардлагатай усан халаалтын зуух худалдан авах зардалд зориулж, 150,000,000 (нэг зуун тавин сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ